

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2021 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос **ТОГТООХ нь:**

1. Хэнтий аймгийн Хэрлэн сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Батлагдсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Хэнтий-Ус” ХХК /Г.Батгэрэл/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ тариф, зах зээлийн газар /Б.Болор-Эрдэнэ/-т даалгасугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 224 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

А.ТЛЕЙХАН

ЗОХИЦУУЛАГЧ

Э.ТҮВШИНЧУЛУУН

ЗОХИЦУУЛАГЧ

Б.БАТТУЛГА

ЗОХИЦУУЛАГЧ

У.МЯГМАРСҮРЭН

ЗОХИЦУУЛАГЧ

Э.САМДАН

Эрчим хүчний зохицуулах хорооны

**ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ
ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

1. Хэнтий аймгийн Хэрлэн сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/	
1	Төсөв болон үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м ³	1,500.0	
	Төсөв болон үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	хувьсах	Төг/ГЖ	25,754.8
		тогтмол	Төг/м ³	813.6
2	Төсөв болон үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэрэгцээний ус халаасан дулаан	Төг/м ³	3,000.0	
3	Орон сууцны халаалт (оюутны байр, подвал, "0" –ын өрөөний халаалт хамаарна)	Төг/м ²	800.0	
4	Ахуйн хэрэгцээний ус халаасан дулаан	Төг/м ³	3,000.0	
5	Дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф	41 м ² хүртэл талбайтай айл өрх	Төг/м ³	3,000.0
		41-81 м ² талбайтай айл өрх	Төг/сар	5,000.0
		81 м ² -с дээш талбайтай айл өрх	Төг/сар	10,000.0